| 2 | заалт | зохион байгуулж дүгнэх | | судасны өвчлөл зэргээр/ авч түүний дагуу сургалтын төлөвлөгөө боловсруулан, эрүүл мэндэд тохирсон сургалт зөвлөлгөөг өгч ажиллаад, үр дүнг 6 сард тооцож, шагнаж урамшуулахаар төлөвлөсөн.<br>- Эрүүл мэндийн төвд хэрэгжиж буй 9 үндэсний хөтөлбөр, 4 дэд хөтөлбөр, 3 стратегийг бүх мэргэжилтэнгүүдэд хувиарлан өгч, гэрчилгээжүүлэн, хэрэгжилтийг хагас жилээр гарган ЭМГ-т хүргүүлсэн.Үндэсний болон дэд хөтөлбөр, стратегийн хэрэгжилт 90-95 хувьтай байна.<br>Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зорилтот бүлэгт чиглүүлэн хийлээ .<br>1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сүрьеэ өвчин . гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх, тарваган тахал өвчин болон байгалийн голомтот халдварт өвчин, халдварт шар өвчин, томуу томуу тест өвчин, ДОХ БЗДХӨ нөөс урьдчилан сэргийлэх болон амны хөндийн эрүүл ахуй, зэрэг сэдвүүдээр мэдээлэл сургалт сурталчилагааг нийт 1560 иргэн хүүхэд залуучууд өсвөр үеийнхэнд хийж мэдлэгийн түвшин 25 хувь нэмэгдсэн байна<br>.<br>2. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Осол гэмтэл түүнээс урьдчилан сэргийлэх, зөв зохистой хооллолт, чихрийн шижин өвчин түүнээс урьдчилан сэргийлэх, идэвхтэй хөдөлгөөн, зүрх судасны өвчин, архи тамхины хор хөнөөл түүнээс татгалзах арга замууд зэрэг сэдвүүдээр мэдээлэл сургалт сурталчилгааг хийж нийт 1800 иргэн хүүхэд залуучууд хамрагдан тухайн сэдвүүдээр эрүүл мэндийн мэдлэгийн түвшин дундажаар 30 хувь нэмэгдсэн байна.<br>Сургалтуудыг анги танхим, хурал цуглаан, ажлын байр, хөдөө багуудын хот айл өрх гэрээр явж харилцан ярилцах, дүрийн тоглолт хийх, лекц хэлбэр, бүлгээр ажиллуулах зэрэг хэлбэрүүд хийлээ.Сургалтанд хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийг бүртгэлжүүлэн зурагжуулан тайланд хавсаргалаа.<br>-2, 3, 4, 5 дугаар багууд, албан байгууллага, хороо хориноор | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | явж, иргэдийн халдварт бус өвчний талаарх судалгаа/архи тамхи, давс сахарын хэрэглээ, биеийн жингийн индекс, артерийн даралт, дасгал хөдөлгөөн хийдэг эсэх, зүрх судасны өвчлөл зэргээр/ авч, судалгааны нэгтгэлийн 5 багаар гарган, түүний дагуу сургалтын төлөвлөгөө боловсруулан, эрүүл мэндэд тохирсон сургалт зөвлөлгөөг өгч ажиллаад, үр дүнг 2019 оны 3 сард тооцож, шагнаж урамшуулахаар төлөвлөсөн.<br>-Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд "Осол гэмтлээс сэргийлье", "Малчдын эрүүл мэндийг дэмжих", "Архидан согтуурахаас сэргийлэх", "Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр", "Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих", ""Бөөр хамгаалах дэлхийн өдөр", "Давсны хэрэглээг бууруулах өдөр", "Тамхины эсрэг дэлхийн өдөр", "Эх үрсийн эрүүл мэнд", "Сүрьеэтэй тэмцэх өдөр", "Эрүүл гэр бүлийг дэмжих өдөр", "Хөдөлгөөн эрүүл мэнд", "Тарваган тахлын халдвараас сэргийлье", "Эмийн зохистой хэрэглээ", "Олон улсын охидын өдөр", "Гар угаах дэлхийн өдөр", "ДОХ-той тэмцэх өдөр", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр", "Дэлхийн гар угаах өдөр"-үүдээр 19 удаа удирдамжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулан, давхардсан тоогоор 1510 хүн хамруулсан. | |
| 33 | Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд | Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг сайжруулах | Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 80 хувиас дээш байна | Үндэсний хөтөлбөр 9, дэд хөтөлбөр 4, үндэсний стратеги 2 хэрэгжиж байна. Хөтөлбөр хэрэгжилт "сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр 70.3%-тай бусад хөтөлбөрийн биелэлт 80 хувиас дээш байна.<br>Эрүүл мэндийн төвд хэрэгжиж буй үндэсний 9 хөтөлбөр, 4 дэд хөтөлбөр, 3 стратегийг бүх мэргэжилтэнгүүдэд хуваарилан өгч, гэрчилгээжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган ЭМГ-т хүргүүлсэн.<br>-Үндэсний болон дэд хөтөлбөр, стратегийн хэрэгжилт 90-95 хувьтай байна. | 100 |
| 34 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 36 дахь | Хөдөөгийн багийн эмч нарын чуулга уулзалтанд багийн эмч нарыг оролцуулах | 5 багийн эмч оролцоно. | Багийн эмч нарын анхдугаар чуулга уулзалт тэмцээн, сургалтанд багийн эмч Д.Мөнхжаргал, Н.Чимэдцэез, Л.Дугар нар хамрагдан сургалт мэдээллээр хангагдан бусадтай туршлага солилцон багийн эмч нарын анхдугаар чуулга уулзалт, сургалт, ажил мэргэжлийн уралдаан"-д 5 | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | заалт | | | дугаар багийн эмч Д.Мэнхжаргал амжилттай оролцож цалингийн 20 хувиар шагнагдсан. | |
| 35 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 38 дахь заалт | Эмч, эмнэлгийн ажилчдын ажлын ачааллыг тооцох, ачааллыг бууруулж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар цалин урамшууллын системийг бодит ачаалалтай уялдуулж тооцох | Эмч, ажилчдын ажлын ачааллын тандалт судалгаа хийгдэж , цалин урамшуулал олголтын байдалд эерэг хандлага гарна. | Орон тооны 3 их эмч , хөдөөгийн 5 багт 3 бага эмч, эх баригч бага эмч-1, Дүн бүртгэгч бага эмч-1, вакцинатор сувилагч-1, ахлах сувилагч-1, ээлжийн сувилагч-4, үйлчлэгч-2, ариутгагч-1, лаборант-1, тогооч-1, нярав-1, нийгмийн эрүүл мэндийн ажилтан-1, жолооч-1, нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.Их эмч 1, багийн эмч 2 дутагдалтай байгааг Эрүүл мэндийн газарт ажлын байрны зарыг хүргүүлсэн.<br>-Цалин урамшууллын системийг Засгийн газрын 150 дугаар тогтоолын дагуу тооцож, илүү цагийг сар бүр /их эмч нар, жолооч, эх баригч, сувилагч нарт/, ур чадварыг сар бүр /тогооч, үйлчилэгч, нярав, жолоочид/, үр дүнгийн нэмэгдлийг улиралд бүр /бүх ажилчдад/ ажилчдын хийсэн ажил, тайланд үндэслэн тодорхой хувиар тооцон өгч байна<br>-Орон тооны 3 их эмч , хөдөөгийн 5 багт 4 бага эмч, эх баригч бага эмч-1, Дүн бүртгэгч бага эмч-1, вакцинатор сувилагч-1, ахлах сувилагч-1, ээлжийн сувилагч-4, үйлчлэгч-2, ариутгагч-1, лаборант-1, тогооч-1, нийгмийн эрүүл мэндийн ажилтан-1, жолооч-1, нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.<br>-Их эмч 1, багийн эмч 1 дутагдалтай байгааг Эрүүл мэндийн газарт ажлын байрны зарыг хүргүүлсэн.<br>-Нярав, 2 дугаар багийн эмч, ээлжийн 1 сувилагч ар гэрийн асуудлаар чөлөө авсан.<br>-Шинээр 1 ээлжийн сувилагч авсан.<br>- Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 263 дугаар тогтоол, 264 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 6 дугаар хавсралтын дагуу Эрүүл мэндийн төвийн даргын 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 41 тоот тушаалаар эмч ажилчдын цалинг шинэчлэн тогтоон олгож байгаа.<br>-Эмч ажилчдад улирал бүр ажлыг дүгнэн, урамшууллыг олгож байна.<br>- Эхний хагас жилээр хоолны мөнгө 4176000 төгрөг олгосон.<br>-Дотоод албан томилолтонд-384 000 төгрөг зарцуулсан.<br>-"Ажил мэргэжлийн уралдаан"-д амжилттай оролцсон 3 | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | ажилтанг цалингийн тодорхой хувиар шагнасан. -Тэтгэвэр, тэтгэмжинд-15000 600 төгрөг олгосон/Тогоч Р.Гэрэлмаа/ -Хөдөө орон нутагт 3 жил тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмжинд 13 хүнд- 46000 200 төгрөг олгосон | |
| 36 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-Б-7 дэх заалт | Ахмадын эмчилгээ, сувилгааны өрөөг бий болгох, өндөр настанд гэрээр үйлчлэх үйлчилгээг эрчимжүүлж хэвшүүлэх | Үйлчилгээ үзүүлсэн ахмадуудын тоогоор | Ахмад настангуудад настны аэробекийн дасгал, хийн дасгал заасан, ажлын байрны дасгалыг бүх төрийн болон төрийн бус байгууллагууд хийдэг болсон. Бие бялдар чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг ахмад настан 80 гаруй хүнээс авч цахим хаягт нь шивж оруулсан больницд хэвтэн үйлчлүүлж байгаа иргэдэд эмчилгээний биеийн тамирын дасгал заасан. 7 хоногийн 5 дахь өдөр болгон өглөөний 7 цагт нарны алхалтаар ходоодны рашаан хүртэл алхаад булгаасаа уугаад, дасгал хийдэг болсон. Ахмад настангууд 5 дахь өдөр бүрийн 14 цагт цуглаж дасгалаа хийхээс гадна чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж соёл спортын төвийн бүжгийн багшаар заавал сурах стандарт 10 бүжиг заалгаж, зааланд оруулах зэргээр хамтран ажиллаа. -2018 оны 12 сараас ахмадын өрөөг гаргаж өгөхөөр болсон. | 100 |
| 37 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-Б-8 дэх заалт | -Эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн засвар хийх -Уламжлалт эмчилгээг өргөжүүлэн, физик эмчилгээний тоног төхөөрөмжтэй болох | Уламжлалт эмчилгээг эрчимжүүлэн, физик эмчилгээний тоног төхөөрөмжтэй болсноор | Хөдөөгийн багуудад зуны улиралд хүүхдийн сувилал ажиллуулах төсөл бичиж, НҮБ-ийн Хүн амын сангийн мэргэжилтэнд хүргүүлсэн. -Уламжлалт эмчилгээний үйл ажиллагааг чийрэгжүүлэлтийн өрөөнд чийрэгжүүлэлтийн сувилагч Б.Алтанчимэг, вакцинатор сувилагч Д.Лхагвадулам нар хийж байна. 2020 онд Эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барихаар болсон. -Уламжлалт эмчилгээг өргөжүүлэн, физик эмчилгээний тоног төхөөрөмжтэй болох шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг ЭМГ-т болон УИХ-ын гишүүн Л.Элдэв-Очирт санал хүргүүлсэн. | 70 |
| 38 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх, хөгжлийг дэмжих, сургалт | Эрүүл мэндийн төвийн эмч нар сургалтанд | -Хөгжлийн бэрхшээлтэй 15 хүүхдийн судалгааг гаргаж, эмч эмнэлгийн мэргэжилтнүүд хуваарийн дагуу 7 хоногийн 3 дахь өдөр үзлэг хийж, төрөлхийн зүрхний цоорхойтой 3, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хөтөлбөрийн 27 дахь заалт | дадлага нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх | хамрагдаж дадлагажина | төрөлхийн суумгай 2 хүүхэд үзэж, эцэг эх асран халамжлагч нарт нь зөвлөгөө өгч байна.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй суманд байгаа хүүхдүүдийг гэрээр очиж үзэж шаардлагатай эмийг хөнгөлөлттэй жороор бичиж үйлчилж байгаа<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд үйлчлүүлэхэд ээлтэй орчин бүрдүүлж, эмнэлгийн гадна үүдний хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд ороход саад бэрхшээлгүйгээр орж гарах орчин бүрдүүлсэн.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран хамгаалагч нарт эрүүл мэндийн чадавхжуулсан сургалт хийх хувиар гарган сургалтыг 2 удаа хийсэн. | |
| | **Г.СОЁЛ УРЛАГ, СПОРТ**<br>**Зорилго: Соёл урлагийг бүх талаар дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | |
| 39 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 85 дэх заалт | "Эрхэт хайрхан"-ы аймгийн тахилга наадам, Сарлагийн фестиваль зохион байгуулах | Төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь чанартай зохион байгуулснаар | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 41тоот тогтоолоор аймгийн тахилгат уул болгож, Хангайн нурууны 2 дахь ноён оргил Эрхэт хайрханы тэнгэрийг тайх ёслолын арга хэмжээ 6 сарын 22-ны өдөр боллоо. Уг арга хэмжээнд аймгийн Засаг дарга, газар, хэлтсийн дарга нар, УИХ ын гишүүн Г. Занданшатарын бие төлөөлөгч, зарим сумдын удирдлагууд, Гачэн лам шавь нарын хамт хуралцан ирж, төрийн тахилга, буян номын зан үйл хийн, эрийн гурван наадам хийж өргөн дэлгэр зохион байгууллаа."Зургаан түмэн сарлагийн баяр"-ыг 07-р сарын 29-ний өдөр 6 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдсан. Дээрх наадамд 7000 гаруй иргэд, аялагчид, 6 сумын малчид, төлөөлөгчид оролцсон. | 100 |
| 40 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 44 дэх заалт | Аймгийн соёл урлагийн их наадамд уран сайханчдыг оролцуулах | Урлагын их наадамд иргэд оролцсон байна. | Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Хүүхдийн урлагийн их наадамд амжилттай оролцлоо. Дээрх наадмын 1-р шатны шалгаруулалтыг сумын хэмжээнд зохион байгуулж, шалгарсан бүжгийн хамтлаг аймгийн уралдаанд оролцон, Гуравдугаар байранд шалгарсан. | 100 |
| 41 | Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл | Соёлын төвийн барилгын их засвар хийх | Засвар бүрэн хийгдсэн байна | 2019 оны шинэ Соёлын ордоны барилга баригдахаар улсын төсөвт тусгагдсан | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хөтөлбөр | | | Энэ ажил 2019 онд хэрэгжилнэ. Зураг төсөв хийгдсэн. | |
| 42 | Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн В-1 | Соёлын төвийн үзэгчдийн суудлыг шинэчлэх | Шинээр 200 суудал тавьсан байна | Үзэгчдийн суудлыг 50 хувь шинэчилсэн. 75 хүний суудал бүхий 15 ширхэг сандлыг нэмэлт санхүүжилтийн хөрөнгө 4.445.900 төгрөгөөр шийдвэрлэсэн. | 100 |
| 43 | Соёлын өвийг хамгаалах тухай хууль | Соёлын салбарт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг хангах | Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг 80-с дээш хувьд хүргэнэ | .Соёлын салбарт хэрэгжиж байгаа Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажилладаг. Дэд хөтөлбөрийн хүрээнд сумын нутаг дэвсгэрт хийгдэх ажлын төлөвлөгөөг ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан мөрдөж ажиллаж байна. | 70 |
| 44 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 44 дэх заалт | "Өвлөн бүжье" Улсын уралдаанд сурагчдыг оролцуулах | Уралдаанд оролцож амжилт гаргаснаар | Уралдаанд Д.Дамдинжав багштай бүжгийн дугуйлангийн сурагчид оролцож Мөнгөн медалиар шагнагдсан. "Алтан ураг" хамтлагийн хүүхдүүд Хамтлаг бүжиг болон Хосын төрөлд Дэд байрт шалгарсан амжилт гаргасан.. | 100 |
| 45 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-В-5 | Үндэсний биеийн тамир спорт, соёл урлагийн ажлыг бололцоотой хэлбэрээр дэмжих, бөх морь цоллооч уралдааныг уламжлал болгон зохион байгуулж цоллооч балтгах | Явагдах уралдаан тэмцээн зохион байгуулагдаж, оролцогчдийн тоо өссөн байна | Үндэсний уламжлалт тоглоом наадгай, урлагийг иргэдэд сурталчилах зорилгоор оньсого таалцах, түргэн хэллэг, шагайн наадгай зэргийг хүүхэд, иргадийн дунд зохион байгуулж, монголын хөлөгт тоглоом "Үүчүүр"ийг сумын ахмад настнуудтай хамтран хүүхэд багачуудад заасан.<br>Үндэсний бөхийн барилдааныг сумын хэмжээнд хүүхдүүд, бөх сонирхогч залуучуудын дунд 11 удаа, мөсний баяр 1 удаа, сур харваа 1 удаа, шагайн наадгайг 3 удаа тус тус зохион байгуулсан . Дунд сургуулийн 6-12-р ангийн сурагчдын дунд Морь, бөх цоллоочдын уралдаан"-ыг уламжлалын дагуу зохион байгуулж дүгнэсэн.<br>Үндэсний спорт, урлаг соёлыг иргэд хүүхэд залууст сурталчилах зорилгоор зохион байгуулагдсан дээрх арга хэмжээ урьд оны мөн үеэс 10 хувиар өссөн ба 1000 гаруй иргэд, залуучууд, сурагчид оролцсон.<br>Уламжлалт хөлөгт тоглоом заасан нь шинэлэг ажлын нэг байсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 46 | МУЗГ-ын 247 дугаар тогтоолоор батлагдсан "Журам батлах тухай" | "Угийн бичиг" хөтлөх сургалт хийж, сургалтын ахиц чанар үр дүнгийн тоог нэмэгдүүлэх | Өмнөх түвшнээс 15 хувиар нэмэгдүүлнэ | "Удмаа мэдье, ургаа бататгая" сургалтыг иргэдийн дунд 1 удаа зохион байгуулсан. Дээрх уриан дор аян зохион байгуулахаар төлөвлөж байна. Угийн бичгээ 4 айл, ах дүү, үр хүүхдүүдийн хамтаар шинээр хөтөлж эхэлсэн. | 70 |
| 47 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-В-3 | Спорт зааланд урсгал засвар хийх | Гэрэлтүүлэг нэмж, шал будсан байна | Урсгал засварын будгийг авч бэлдсэн. Цахилгааны монтажийг мэргэжлийн хүнээр солиулан аюулгүй байдлыг хангасан.Гэрэлтүүлгийг шинэчилж, мэргэжлийн ажилтнаар монтажны аюулгүй байдлыг хангасан. Шалны будаг шинэчилсэн. | 100 |
| 48 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-В-3 | "Дуутай хуруу "уламжлалт наадгайг Соёлын өвд бүртгүүлэх ажлыг үргэлжлүүлж гэрчилгээ авах | Уламжлалт өв соёл бүртгэгдэнэ | Дуутай хуруу наадгайг соёлын өвд бүртгүүлэх бэлтгэл ажлыг 100 хувь хангаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн. Үүнд соёлын биет бус өв өвлөн уламжлагч 40 гаруй хүнийг Бүртгэл мэдээллийн санд авч, мэдээллийн санг баяжуулсан. | 100 |
| 49 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-В-3 | Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг хамгаалах ажлыг сумын ИТХ-ын тогтоол, засаг даргын захирамжаар багийн Засаг дарга, иргэдэд хариуцуулах | Түүх соёлын өв иргэдийн хамгаалалтанд авагдана | 31 дурсгалт газрын 500 гаруй үл хөдлөх дурсгалыг Бүртгэл мэдээллийн санд авч, сумын Засаг даргын захирамжаар иргэд, малчдад гэрээгээр хариуцуулан, хамгаалалтад авсан.<br>31 дурсгалт газрын 500 гаруй үл хөдлөх дурсгалыг Бүртгэл мэдээллийн санд авч, сумын Засаг даргын захирамжаар иргэд, малчдад гэрээгээр хариуцуулан, хамгаалалтад авсан. | 100 |
| 50 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-В-10 | Малчдын дунд сумын Засаг даргын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн, сумын "Аварга шалгаруулах үндэсний бөхийн барилдаан зохион байгуулах | Тэмцээн уралдаанд оролцох малчдын тоо өссөн байна | Малчдын дунд урлаг, спортын уралдаан тэмцээн 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 900 гаад иргэд малчид хамрагдсан. Волейболын тэмцээнийг сумын засаг дарга ивээн тэтгэн 4 дэх жилдээ амжилттай явагдсан. Мөн "Малчид дуулж байна" уралдааныг ИТХ, Засаг даргын ивээл дор явагдаж 50 гаруй малчид оролцож 6 малчин Утай гумбэн, Улан Үдэ явах эрхийн бичгээр шагнагдсан. Мөн Сэнжитийн 1-р багийн Өдөрлөг зохион байгуулж, иргэд, байгууллагын албан хаагчдын дунд Волейболын тэмцээн, дээрх багийн малчид оролцсон Шоу цэнгүүнийг багийн Засаг дарга Х.Ганболд, Нийгмийн халамж, үйлчилгээний мэргэжилтэн Д.Амгаланзул нартай хамтран зохион байгуулсан.<br>Уламжлалын дагуу сумын Засаг дарга нэрэмжит Волейболын тэмцээн 03-р сард амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээнд төв хөдөөгийн 6 багийн 100 гаруй | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | малчид идэвхитэй, өрсөлдөөнтэй оролцсон. Үндэсний бөхийн барилдааныг 11 удаа зохион байгуулсан. Бөх сонирхогч залуучууд, хүүхдүүдийн тоо урьд оны мөн үеэс 2 дахин өссөн. | |
| | **Д. НИЙГМИЙН ХАЛАМЖ ХАМГААЛАЛ** | | | | |
| **Зорилго: иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн нийгмийн халамж , хамгааллын оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | |
| 51 | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 57 дахь заалт | "Өрх толгойлсон эцэг эхийн нийгмийн хамгааллыг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх | Өрх толгойлсон эцэг эхийн нийгмийн баталгаа хангагдана | Өрх толгойлсон эх,эцэгт олгох тэтгэмжийн тухай хуулъ шинэчлэгдэн батлагдаж 2018 оны 01 сарын 01-нээс хэрэгжсэнээр сумын хэмжээнд хуулийн дагуу материалаа 11 эх эцэг бүрдүүлэн өгч улиралд 1 удаа 240,0 төгрөгийн тэтгэмж авч эхний 3 улирлын байдлаар 6780,0 төгрөгийг Нийгмийн халамжийн сангаас олгосон. | 100 |
| 52 | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 57 дахь заалт | Ахмадууд мэдлэг туршлагаа залуустай хуваалцах тэдэнд өвлүүлэх " Хүн ахтай дээл захтай" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх | Төслийн уралдаанд оролцож , хэрэгжүүлсэн байна | "Ахмадаас суралцая" төслийг Цоғц эрдэм сургууль дээр хэрэгжүүлэн 3 ахмад багшаар сургалтын төлөвлөгөө гаргуулан баталж залуу багш, сурагчдад хичээл заалган туршлага хуваалцлаа. Ахмад оёдолчин Д.Цэвэлмаа мөн санхүүгийн дэмжлэгт хамрагдан 2 залууд оёдол эсгүүрийг зааж дадал олгосон. | 100 |
| 53 | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 57 дахь заалт | Сум багийн түвшинд нийгмийн түншлэлийн багтай хамтран дэмжлэг туслалцаа шаардлагатай ахмад настны нөхцөл байдлыг судлан тогтоож, хэрэгцээт дэмжлэг туслалцаа , үйлчилгээг тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэх | Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 90 –с дээш хувьтай байна. | Нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай ахмад настанд нийгмийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх ,зөвлөн туслах ,ахмадын хороотой хамтран дэмжлэг туслалцаа шаардлагатай ахмадуудад нийгмийн үйлчилгээнд хамруулж байна. Насны хишиг " үйлчилгээнд 134 ахмад,Нийгмийн халамжийн тэтгэмжийн үйлчилгээнд 33 ахмад ,хөнгөлөлт тусламжид 8 ахмад хамрагдлаа.<br>"Ахмадаа ачлая"хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдсан үүнээс сумын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган сумын Засаг даргаар батлуулан ахмадын хороо бусад салбаруудтай хамтран ажиллаж байна.Ахмадын амралт чөлөөт цагийг өнгөрүүлэх ахмадын танхимыг тохижуулснаар ахмадууд долоо хоногийн Баасан гаригийн 14 цагт тогтмол цуглан эрүүл мэндийн үзлэгт хамрагдах,хөдөлгөөнөөр хичээллэн,Соёл спортын төвд бүжгээр хичээлэх, сургалт мэдээл авах зэрэг үйлчилгээнүүдэд тогтмол давтан | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | тоогоор 50-60 ахмад хамрагдаж байна.Нийгмийн халамжийн сангаас дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай ахмадуудад эрүүл мэндийн төвийн тодорхойлолт нөхцөл байдлын үнэлгээний дагуу тэтгэмжид 36 ахмад хамрагдан улиралд эм тариа асаргаа сувилгаанд нь 60,0 төгрөгийн дэмжлэг үзүүлж байна. | |
| 54 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-Г-6 дахь заалт | Өрхийн хөгжил –зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | Зорилтот өрхийн хөгжил хамгааллын ажлын төлөвлөөний 2018 оны шалгуур үзүүлэлт хангагдана | Хөтөлбөрт хамрагдах 2018 оны 15 өрхийг сонгон өрхийн гэр үнэлгээг 2 удаа хийсэн ,1-р үнэлгээний дагуу хэрэгжүүлэх өрхийн хөгжлийн төлөвлөгөөг өрх бүр хийж ,2-р үнэлгээгээр өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлсэн талаар үнэлгээг хийхэд 15 өрхийн үнэлгээгээр хөгжлийг дэмжигч 15 өрх хөгжлийн төлөөх өрх болох зорилготой.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл зан үйлийн дадлыг хэвшүүлэх сургалт мэдээллийг 4 удаа хийснээр өрхүүд хүнсэндээ хүнсний зориулалтын сав хэрэглэх зорилгыг тавьж, хэрэглээндээ анхаарснаар 15 өрх төмөр шанага хэрэглэж эхэлсэн,өрхийн гишүүдийн нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Долоо хоног бүрт цуглуулан Гэр бүлийн харилцаа ба хандлага,Нийгмийн халамжийн тухай ,Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай төсөл,хөтөлбөр,Хүн байхын утга учир,Газрын тухай,Эрүүл мэндийн тухай хуулиудаас сургалтыг 8 удаа зохион байгуулж мэдээ мэдээллийг өглөө.,Соёл спортын төвийн багш Дамдинжаваар заавал сурах бүжгээс заалган,8 удаа бүжгийн дугуйланд хичээллэсэн,номын санд уншигчийн карт нээлгүүлэн ном уншин тэмдэглэл хөтлүүлснээр өрхийн гишүүдийн бичих чадварыг дээшлүүлэхэд анхаарч номын тэмдэглэл хийлгэсэн, Соёл спортын төвд гар бөмбөгөөр 8 удаа хичээллэсэн.Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор дундын хадгаламжийн сантай болгон өрхийн төсвөө хянаж сурахад нь дэмжлэг болж байна.Мөн нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэхийн тулд гэр бүлийн өдрөөр өрхийн гишүүдээр урлагийн тоглолт | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | тоглууллаа. Өрхийн дэлгэрэнгүй судалгаа гаргасан.Өрхийн айчлалыг АДЗ-ийн гишүүд 1 удаа хийж өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцтай танилцсан. ОНОТХҮ-ий бүлгийн зохион байгуулалттай хөдөлмөр эрхлүүлэхээр төсөл бичүүлэн ХХҮГ-т хүргүүлснээр 1,5 сая төгрөгийн дэмжлэгийг олгон өрхүүд блок үйлдвэрлэх тоног төхөөрөмжтэй болсон. | |
| 55 | Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын тухай хууль | Малчдын Нийгмийн даатгалын сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрах хүрээг нэмэгдүүлэх | Сайн дурын даатгалд 90, Эрүүл мэндийн даатгал 95 хувьд хүргэх | Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдалт 2018 оны хагас жилийн байдлаар шинээр 34 даатгуулагч хамрагдаж,хамрагдвал зохих иргэдийн 3 хувьтай хамрагджээ.2018 оны хагас жилийн байдлаар 155 даатгуулагч гэрээ хийж даатгуулсан ба төлөвлөгөө 23106,7 сая төгрөг санд оруулахаас 22250,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн.<br>Иргэдэд 4 удаа сургалт баг,өрх айлаар явж хийсэн 196 даатгуулагчтай гэрээ хийснээс 43 иргэн нь шинээр даатгуулсан, 196 даатгуулагчаас 53000,0 сая төгрөг санд оруулж төлөвлөгөө 100 хувьтай байна . нийт хамрагдалт 1024 иргэн хамрагдаж энэ онд 3 хувиар өссөн байна. Эрүүл мэндийн даатгалд 813 даатгуулагч хамрагдаж,санд 28992,0 мя төгрөг оруулж төлөвлөгөө 90,6 хувьтай хамрагдалт 80 хувьтай байна. | 100 |
| 56 | Улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд | Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдүүлгийг хүлээн авч, өмчлөх эрхийг баталгаажуулах | Өмчлөх эрхээ баталгаажуулсан иргэдийн тоо | 2018 оны хагас жилийн байдлаар Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр нийт 1008 бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажилласан. Үүнээс эд хөрөнгийн 31 бүртгэл хүлээн авч Улсын бүртгэлий хэлтсийн Эд хөрөнгийн тасагт хүргүүлсэн. Мөн аймгийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 242 дугаар зүйлд заасан "Аймаг, сумын хэмжээний үл хөдлөх эд хөрөнгийн судалгааг хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд нэгтгэн гаргаж холбогдох байгууллагуудын мэдээллийн зөрүүг арилгах ажлыг зохион байгуулах" ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагуудын газар эзэмших эрхийг | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | зд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хамруулах ажлын хүрээнд өөрийн сумын төрийн байгууллагын газар эзэмших эрхийн бүртгэлийн судалгааг гаргасан. | |
| 57 | Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд | Нийгмийн 3 талт зөвшил хэлэлцээрийг байгуулан хэрэгжилтийг тооцож сумын хөгжилд төр, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх | Зөвшилцөл хэлэлцээр байгуулж үр дүнг тооцсноор | Сумын Нийгмийн 3 талт зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн байгуулагдсан.Аймгийн ҮЭ-ийн хорооноос Нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийн дагуу сургалтыг зохион байгуулсан үүнд Сумын ЗДТГ-ын дарга оролцсон. Ажил хөдөлмөр эрхлэгч иргэдийн цалин хөлсийг нэмэгдүүлэх зарим ажлын байрны шатлалыг ахиулах талаар саналыг Аймгийн Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэнд уламжлан тайландаа бичин хүргүүлсэн. | 70 |
| | **Хоёр. Эдийн засгийн өсөлт үйлдвэр үйлчилгээ, бүтээн байгуулалт** | | | | |
| 58 | Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль, шилэн дансны тухай хууль, холбогдох тогтоол, шийдвэр журам | Орон нутгийн урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл тогтвортой, сахилга баттай санхүүгийн "Тунгалаг төсөв" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажилах | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 95%-д хүргэнэ, Аудит санхүүгийн хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг бууруулна, НББ хөтлөлтийг сайжруулна, ОНХС-ийн төлөвлөлт гүйцэтгэлийг сайжруулж, ХАА-г хуулийн дагуу зохион байгуулж хэвшинэ. | Шилэн дансны мэдээллийг төсөвт байгууллага тус бүрээр хууль, журманд заасан хугацаанд сар, улирлаар мэдээллэж ажилласан.Сумын төсөвт 6 байгууллага тус бүр шилэн дансны мэдээллийг хөтлөж, цаглабарын дагуу сар бүр төсөөс нийтэд ил тод мэдээлсэн ажиллаж нийт 1.2 тэр бум төгрөгний давхардсан тоогоор 28 нэр төрлийн мэдээллийг 1-12 удаагийн давтамжтайгаар бүрэн мэдээлсэн. | 100 |
| 59 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 5 дугаар сарын 31 ний өдрийн "Журам батлах тухай" 276 дугаар тогтоол | Орон нутгийн өмчит бүх байгуулагуудын эзэмшлийн газар, хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэж, балансад бүрэн тусгаж, өмч хөрөнгийн хөдөлгөөнийг цахим програмаар явуулах | Программ ашиглалт 100 хувь болно | Байгууллагуудын эзэмшлийн газрын эрхийг шинэчлэн бүртгүүлэхээр аймгийн ГХХБГ-т хүргүүлсэн. Байгууллага бүр дээр төсөв захирагчийн шийдвэрээр 3-5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон ажиллаж, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг зохион байгуулан ажиллаж, дүн мэдээг 2018 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд тусган Орон нутгийн өмчийн газарт байгууллага тус бүрээр хүргүүлж , өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг цахим системд бүртгэлжүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 60 | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-6 | Өрхийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор сүүний үйлдвэр байгуулах | Үйлдвэр байгуулагдсан байна. | Суманд Витафит компаний сүүний үйлдвэр байгуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг 2018 онд багтаан 100% ашиглалтанд оруулж, ирэх онд үйл ажиллагаа нь жигдэрнэ. | 100 |
| 61 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-10 дахь заалт | "Нэг сум нэг баг байгууллага, нэг шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээ" хөдөлгөөн өрнүүлж баг бүр 1 бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох | Бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болно | Жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаж байгаа "Таван түмэн сарлагийн баярын "Эвент" арга хэмжээг зохион байгуулж сарлаг үхрийн уламжлалт арга ажиллагаа, зан үйлийг харуулсан олон төрлийн уралдаан тэмцээн явуулж, Мөн брэнд бүтээгдэхүүн болох сарлагийн цагаан идээгээ улс, аймаг, гадаадын улс оронд сурталчилах ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 62 | Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөбөрийн 1-5-1 дэх заалт | Хот айл жуулчны бааз төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Малчдын нөхөрлөлийн үйлчилгээг өргөжүүлж үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх | Сумын аялал жуулчлалын дотоод маршрут бүй болгож брэнд бүтээгдэхүүн болох сарлаг үхэр, түүнээс гарах цагаан идээ, бусад бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын аялагч, жуулчдад сурталчилах, Баянхонгор аймгийн Аялал жуулчлалын газартай хамтран Дөш хайрхан нөхөрлөлийг түшиглэн хот айл, жуулчны бааз байгуулан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр ажиллан "Дөш хайрхан" нөхөрлөлийн малчны хот айл амрагч, аялагч 950 гаруй хүнд зочлох үйлчилгээ үзүүлэн уламжлалт мал аж ахуйн арга ажиллагааг сурталчлан ажиллаж байна. | 100 |
| 63 | Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-13 | Суманд амины орон сууц төсөл хэрэгжүүлэх | орон сууцны баригдсан байна | Амины орон сууц хөтөлбөрийн хүрээнд малчид, иргэд, төрийн албан хаагчдаас орон сууцны захиалга авч санал боловсруулан барилга угсралтын компаниудад албан ёсоор хүсэлт хүргүүлж, хаус хороолол барих идэвхи санаачлагыг өрнүүлэн ажилласан.<br>Амины орон сууц хөтөлбөрийн хүрээнд малчид, иргэд, төрийн албан хаагчдаас орон сууцны захиалга авч, одоогоор 10 өрх захиалгаа ирүүлсэн. | 40 |
| 64 | Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-15 | Зарим багийн төвийг сэргээгдэх эрчим хүчээр хангах | Багт суурьших ажиллах орчин бүрдсэн байна. | Сэнжит 1-р багийн төвийг сэргээгдэх эрчим хүчээр хангахаар төлөвлөж, шинээр баригдаж байгаа сурууль цэцэрлэгийн барилгыг сэргээгдэх эрчим хүчээр хангахад шаардагдах техник тоног төхөөрөмжийг бэлтгэн ажилласан | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 65 | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 129 дэх заалт | Хатуу хучилттай 2 километр зам барьж эхлүүлнэ | Зам тавигдснаар Гүүр баригдаж дэд бүтэц сайжирсан байна | Хатуу хучилттай авто замын тендер шалгаруулалтыг зохион байгуулж "Бумбат овоо" компанитай гэрээ байгуулан, замын ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн боловч хөрөнгийн эх үүсвэр дутагдаж, ажил чанаргүй болох эрсдэл учирсан. Иймд энэ ажлыг 2019 онд шилжүүлсэн. | 40 |
| 66 | Аймгийн нийгэм эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн Б-26 | Өвгөн жаргалант- Пионер зуслангийн өндөр хүчдэлд холбуулах, санал боловсруулж зураг төсөл хийлгэх | Өндөр хүчдэлд холбогдсноор | Аймгийн нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ТЭЗҮ хийлгэхээр тусгагдсан. Зуслангийн эдэлбэр газрын асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэсэн. | 40 |
| 67 | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дэх заалт | Өрхийн үйлдвэр эрхлэгчдэд өөрсдийн саналаар тоног төхөөрөмж нийлүүлэх бодлого хэрэгжүүлэх | Шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна | Айл өрхүүдээс өрхийн үйлдвэрлэл явуулахад шаардагдах тоног төхөөрөмжийн судалгаа гарган, захиалгыг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Иргэдээс цахилгаан саалтуур, хөлдөөгч, цахилгааны эх үүсвэр нийлүүлэх захиалга авч байна. | 70 |
| 68 | Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-4 | Чулууны үйлдвэр байгуулах үндсэн ажлыг эхлүүлж, ажлын байр нэмэгдүүлэх | Үйлдвэр байгуулагдсанаар | Чулууны үйлдвэр байгуулах ажлын талаар аймгийн удирдлагуудад, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын удирдах хүмүүст санал хүргэж, хөрөнгө оруулагчдад танилцуулж, МУ-н Засгийн газрын 21-100 хөтөлбөрт багтаан батлуулж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| 69 | Аймгийн ИТХ-ын тогтоол | Орон нутгийн өмчлөлд буй хөрөнгийг хувьчлах | Хувьчлах ажил 100 хувь хэрэгжсэнээр | Орон нутгийн өмчлөлд бүртгэлтэй инженерийн хийцтэй шугам сүлжээг хувьчлах ажлыг зохион байгуулсан.мөн төрийн өмчийн байгууллагуудын ашиглалтгүй хуучирсан барилга байгууламжийг худалдан борлуулах, актлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | 100 |
| **Гурав. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**<br>**Зорилго: тааварлаг мал сүрэгтэй , эрчимжсэн газар тариланг хөгжүүлж ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.** | | | | | |
| 70 | Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого | "Хүнсний бүс зориулалтын савгүй аймаг" хөдөлгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Иргэн байгууллага бүгд "Аяны туг" аялуулж хэрэгжилтийг тодорхой | Аймгийн Засаг даргын " хүнсний бүс зориулалтын савгүй аймаг болох" тухай захирамжийн хэрэгжилтийг хангаж Засаг даргын Тамгын газар, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | 4.1.10 дахь заалт | | хувиар хангана | Эрүүл мэндийн төв, сургууль цэцэрлэг, соёл спортын төв зэрэг албан байгууллагууд, үдийн цай хөтөлбөрийн тендерийн оролцогч нарт органик хүнс, хүнсний аюулгүй сав тэдгээрийн ач холбогдлын талаар сургалт, сурталчилгаа хийж байгууллага тус бүрт 2 хоногийн хугацаатай туг аялуулан гал тогооны ундны усны сав, хүүхдийн аяга таваг усны савыг хүнсний зориулалтын сав болгох ажлыг зохион байгуулж547 иргэн, 6 багийн Иргэдийн Нийтийн хуралд хүнсний зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлэх сургалт сурталчилгаа хийж, даавуун торон уут, төмөр сав болон хүнсний зориулалтын уут савны үзэсгэлэн гаргаж гарын авлага материалыг тараасан. 467 малчид хамрагдсан байна. Мэдээллийн цахим хуудсуудаар албан хаагчдын ярилцлага, сурталчилгааны материал, хийсэн ажлын тайланг зурагжуулан баталгаажуулж сурталчилж ажиллаа<br>Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газраас уг аяныг дэмжин мэдээллийн цахим сүлжээнүүдэд албан хаагчдын ярилцлага танилцуулга, гарын авлага тараах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, багийн Иргэдийн Нийтийн хурлуудаар үзэсгэлэн гаргах, сургалт таниулга хийх ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. “Хөх сав, канистергүй аян” хөдөлгөөн өрнүүлж аялан явах тугийг албан байгууллага тус бүр дээр 2 хоногийн хугацаатай аялуулан гал тогооны ундны усны сав, хүүхдийн аяга таваг усны савыг хүнсний зориулалтын сав болгох ажлыг зохион байгуулж 547 иргэн, 6 багийн Иргэдийн Нийтийн хуралд хүнсний зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлэх сургалт сурталчилгаа хийж, даавуун торон уут, төмөр сав болон хүнсний зориулалтын уут савны үзэсгэлэн гаргаж гарын авлага материалыг 467 иргэд малчдад хүргэн, аймагт зохион байгуулагдсан сургалтанд 23 малчин | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | 1 албан хаагч хамрагдан, Засгийн газарт захидал хүргүүлэх ажилд оролцож, 3 малчинд 40 литрийн битон олгуулсан. | |
| 71 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 102 дахь заалт | Монгол мал хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан үр дүнг тооцож ажиллах | Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 90-с доошгүй хувьд хүргэнэ | Монгол мал хөтөлбөрийн 2 дугаар шатны зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулж бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 35787 толгой мал, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 24933 толгой мал хамруулсан.<br>Сумын хэмжээнд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ ханш аймгийн төв болон бусад сумдаас өндөр байгаа ба арьс, ширний 2.0-5.0, хонины ноос 2.0, ноолуур 5.0 төгрөгөөр илүү, мах, сүүний үнэ тодорхой хэмжээнд өссөн үзүүлэлттэй байна. Сарлагийн самнасан хөөвөр 25.0 төгрөг, сарлаг үхрийн борлуулалт нэмэгдэж байгаа нь сумын түвшинд мал сүрэг эрүүл, малын чанар сайн, түүхий эд бүтээгдэхүүний чанар, гарц өндөр байгаатай холбоотой юм.<br>Ноос арьс ширэнд олгох урамшууралд 53 өрхийг хамруулан 9,5 сая төгрөгийн урамшуулал олгуулсан.<br>*Малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн хязгаарлаж гоц халдварт өвчнөөр тайван бус нутаг статусаа хадгалж чадсан | 100 |
| 72 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 102 дахь заалт | "Илгээлтийн эзэн" дэд хөтөлбөрийг дэмжиж хэрэгжүүлэх | Аян зохион байгуулж оролцсон хүний тоогоор | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 75 тоот тогтоолоор батлагдсан "Илгээлтийн эзэн" дэд хөтөлбөрийн хүрээнд Засаг дарга, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж 27 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн 9 малчныг малжуулах төсөлд хамруулав.<br>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 75 тоот тогтоолоор батлагдсан "Илгээлтийн эзэн" дэд хөтөлбөрийн хүрээнд Засаг дарга, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж 2017 онд 27 сая төгрөгийн санхүүжилтээр Л.Батбаяр, Х.Содномзундуй, Ц.Зулбаяр, Д.Бадамдорж, Ч.ГэрэлтОд, Л.Ариунболд, Г.Дашжанцан, Д.Давхарбаяр, М.Эрдэнэ нарын 9 өрх, 2018 онд 17,5 сая төгрөгийн санхүүжилтээр Х.Энхтүвшин, Ж.Дашзэвэг, Г.Нандинцэцэг, Ө.Уранчимэг, З.Дарамсүрэн нарын 5 өрхийг малжуулах төсөлд хамруулсан. Төсөлд хамрагдсан нийт 14 | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | өрхүүдийн төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна. | |
| 73 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 93 дахь заалт | Сум бүр 50 тн-с доошгүй өвс тэжээлийн нөөц, бүрдүүлж малчид өөрсдийн малын тоонд тохирсон өвс тэжээл бэлтгэх ажлыг даалгавар болгон гүйцэтгүүлэх | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-с дээш хувьд хүргэнэ | 2018-2019 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангалтын байдал:Аймгийн 2018-2019 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай сумын Засаг даргын 2018 оны 83 тоот захирамжаар өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын хэсэг байгуулан 2018-2019 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл зохион байгуулалтын ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаа. 6 багийн хэмжээнд хөдөө өвөлжих өрх 571, хүн ам 2501, өндөр настан 108, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 67, 0-5 настай хүүхэд 356, жирэмсэн эх 27 байна. Хаагдаж болзошгүй зам давааны цаана 168 өрхийн 582 хүн ам, үүнээс өндөр настан 18, 0-5 настай хүүхэд 78, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 27, жирэмсэн эх 6, отор хийж байгаа 45 өрхийн 133 хүн ам 7566 толгой мал үүнээс өөр аймгийн нутагт 6 өрхийн 19 хүн ам, эдгээр өрхүүдэд өндөр настан 1, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1, жирэмсэн эх байхгүй, 0-5 настай 5 хүүхэд, 924 толгой мал Архангай аймгийн Булган, Цэнхэр суманд отроор өвөлжинө. Баацагаан, Өлзийт, Баянхонгор сумдаас ирж өвөлжиж буй 5 өрхийн 14 хүн ам ирснээс өндөр настан 2, хөгжлийн бэрхшээлтэй байхгүй, жирэмсэн эх байхгүй, 0-5 настай хүүхэд 1, 1500 гаруй толгой мал байна Сумын аюулгүй нөөцөд өвс 5,5 тн, малчдын гар дээр бэлтгэсэн 65,2 тн өвс, 9,3 тн гар тэжээл, 96 тн хужир бэлтгэсэн байна. | 100 |
| 74 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 93 дахь заалт | Сум баг даатгалын компанитай хамтран ажиллах, сум бүр бэлчээрийн зорилтот хэсгийг өнжөөж, чөлөөлөх | Даатгалд хамрагдсан малын тоо, сайжруулсан бэлчээрийн хувиар | Мал сүргийг эрсдлийн даатгалд 2018 оны байдлаар 152 өрхийн 13200 толгой мал хамруулж 11817103 төгрөгийн борлуулалт хийсэн.Сумын малчид төлчдийн зөвлөгөөнд оролцсон 383 малчид, 6 багийн Иргэдийн Нийтийн хуралд оролцсон 467 малчид, мал бүхий иргэд, холбогдох мэргэжилтнүүдэд сургалт хийсэн. Бэлчээрийн даац хэтэрсэн, зуны сар гарсаар ургац муутай байгаатай холбоотойгоор мал сүргийг даатгалд бүрэн хамруулах, бэлчээрийг өнжөөж чөлөөлөх шийдвэрийг багийн Иргэдийн Нийтийн хурлаар тогтоол гарган, Бэлчээр хамгаалалтыг сайжруулах журмыг хэлэлцүүлж хуралд оролцсон малчдын санал хүсэлтийг авсан.Нийт нутгаар гантай байгаатай холбогдуулан бусад сумдын малчдыг нутаг буцаан сумын Засаг даргын 2018 оны 44 тоот захирамжийг хэрэгжүүлж ажиллаж байна. | 100 |
| 75 | Сумын Засаг даргын | Сарлагийн хөөвөр | Үйлдвэр байгуулах | Хөөвөр боловсруулах анхан шатны үйлдвэр байгуулах, хамтран | 40 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-6 | боловсруулах анхан шатны самнаж угааж цэвэрлэх үйлдвэр байгуулах | ажил эхлэснээр | ажиллах талаар холбогдох албан тушаалтан, компаниудад санал уламжилж байна. | |
| 76 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 97 дахь заалт | Эмчилгээ тэжээлийн болон мал бордох цэгийг бизнесийн зарчмаар байгуулах асуудлыг бодлогоор дэмжинэ | Үйлдвэр байгуулах эхлэл тавина | Орон нутагт эмчилгээ тэжээлийн болон мал бордох цэг байгуулж ажиллах талаар аймгийн зарим удирдлага, бизнес эрхлэгчдэд санал тавьсан. | 40 |
| 77 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 80 дахь заалт | Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах анхан шатны үйлдвэр байгуулах эхлэл тавих | Жижиг үйлдвэр байгуулах эхлэл тавигдсанаар | Суманд Витафит компаний сүүний үйлдвэр байгуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг 2018 онд багтаан 100 хувь ашиглалтанд оруулж, ирэх онд үйл ажиллагаа нь жигдэрнэ. Арьс нэхий боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжөөр хангагдан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл бүрдсэн | 100 |
